

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН БУЯНТ-УХАА ДАХЬ ГАЗРААС  
2018 ОНЫ ДОЛООДУГААР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018 оны 07 дугаар сарын 26

Буянт-Ухаа

Тус газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Засгийн газрын 2010 оны 338, 340 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”, “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам” болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудыг удирдлага болгон иргэнд хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2018 оны 06 дугаар сарын 16-наас 2018 оны 07 дугаар сарын 25-ны өдрүүдэд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1. Монгол Улсын виз, бүртгэлийн талаар:

Тайлант хугацаанд нийт 105 орны 1508 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон бөгөөд визийн шилжүүлэг 27 хийсэн байна. Үүнд, нэг удаагийн орох 1462, хоёр удаагийн орох 3, олон удаагийн орох 16, нэг удаагийн гарах-орох 18, хоёр удаагийн гарах-орох 0, олон удаагийн гарах-орох 9, дамжин өнгөрөх 0, түр ирэгчийн бүртгэл, хасалт 115, оршин суух зөвшөөрлийн хасалт 35, визийн засвар 6, хүчингүй болгосон виз 9 байна.

1.2. Гадаадын иргэдэд тавих хяналт шалгалтын хүрээнд:

Байгууллагын даргын 2018.07.18-ны өдөр баталсан УБ-02/2018-006 дугаартай удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, тус газрын 4 албан хаагч GB1 ангиллаар тус улсад оршин суух зөвшөөрөл хүссэн БНСУ-ын 1 иргэний бодит байдлыг тогтоох зорилгоор оршин суугаа хаягаар 2018.07.23-ны өдөр очиж, баримт бичгийг шалгасан бөгөөд дүгнэлтээ төвд хүргүүлсэн болно.

Түүнчлэн ГИХГ-ын Буянт-Ухаа дахь газрын даргын баталсан БУ2018-08 дугаартай удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2018.07.24-ний өдөр Төв аймгийн Эрдэнэ, Ар хуст, Баянжаргалан, Баян, Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт байрлах Ногоон сор, Ногоон тэнгэр, Мөнхийн баян гал, БНДА компани болон Бөөрөлжүүтийн уурхайд хийж нийт 123 гадаадын иргэний бичиг баримт шалгалаа. Хяналт шалгалт явуулсан талаарх илтгэх хуудсыг тус газрын даргад танилцуулахаар ажиллаж байна.

Бичиг баримтын хуурмаглал шалгах төхөөрөмжийг ашиглан нийт 60 гадаадын иргэний бичиг баримт, мэдээллийг шалгав.

1.3. Захиргааны арга хэмжээ авсан талаар:

Тайлангийн хугацаанд бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн, визийн хугацаа хэтрүүлсэн, оршин суух журам зөрчсөн зэрэг үндэслэлээр 30 гадаадын иргэнд 2,720,000 төгрөг, 9 аж ахуйн нэгжид /хамрагдсан гадаадын иргэн 41/ 12,990,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

1.4. Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэний талаар:

Тайлант хугацаанд Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэн байхгүй болно.

1.5. Хил нэвтрүүлэлгүй буцаасан иргэдийн талаар:

Тайлант хугацаанд Монгол Улсын виз, визийн зөвшөөрөлгүй, ирсэн зорилгоо тодорхойлж чадаагүй зэрэг үндэслэлээр БНЭУ-3, БНАСАУ-1, Катар-1, Харьяалалгүй-1, нийт 6 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан ба гарах визгүй, аж ахуйн нэгжийн албан бичиггүй зэрэг үндэслэлээр Хятад-6, Турк-1, Польш-1, Америк-2, Ирланд-1, Дани-1, Австрали-1, Канад-1, Катар-1, нийт 15 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр гаргаагүй болно.

Харин шүүх, прокурор, ШШГЕГ-ын хүсэлтийн дагуу Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн байхгүй байна.

1.6. Ярилцлагын тэмдэглэл болон баталгаа гаргуулан хил нэвтрүүлсэн талаар:

Монгол Улсад визгүй зорчигч гадаадын иргэн, хөдөлмөр эрхлэх магадлалтай 8 орны 154 иргэнтэй ярилцлага хийж бичиг баримтыг хуулбарлан хилээр гарсан байдалд хяналт тавьж бүртгэл хөтөлсөн болно. Үүнд: Украин-10, Киргиз-17, Филиппин-91, Казакстан-25, Вьетнам-6, Тайланд-1, БНЭУ-2, БНАСАУ-2.

1.7. Иргэний харьяаллын талаар:

Хоёрдмол харьяалал үүсгэсэн 4 иргэнээр өргөдөл-анкетыг бөглүүлэн холбогдох баримт бичгийг хуулбарлан авч төвд хүргүүлсэн.

Хоёр. Дотоод ажлын хүрээнд

2.1. Тушаал, төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаар:

Тайлант хугацаанд тус газрын дарга 4 тушаал батлан гаргасан ба тус газар 2018 оны долоодугаар сард хийх ажлын төлөвлөгөөнд нийт 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд 96 хувийн биелэлттэй гарлаа.

Төвөөс өгсөн үүргийн дагуу тус газрын үндсэн үйл ажиллагааны талаарх хоногийн мэдээг гаргаж өдөр бүр, байгууллагын даргын баталсан албан даалгаврын хэрэгжилтийг гаргаж 2018.06.18-ны өдөр, тус газрын даргатай 2018 онд байгуулсан албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх илтгэх хуудсыг авч дүгнэн энэ сарын 26-ны өдөр, инфографик мэдээнд тусгах Буянт-Ухаа дахь газрын статистик тоог өмнөх оны мөн үетэй харьцуулан гаргаж мөн сарын 25-ны өдөр, ДШДАХ-ээс ирүүлсэн 01 дүгээр зөвлөмжийн ГИХГ-ын Буянт-Ухаа дахь газартай холбоотой заалтын хагас жилийн хэрэгжилтийг гаргаж 2018.07.17-ны өдөр БОНХ-т, ГИХГ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөний хоёрдугаар улирлын тус газартай холбоотой заалтын хэрэгжилтийг гаргаж 2018.06.25-ны өдөр ДШДАХ-т, 2018 онд сургалтад хамрагдсан албан хаагчдын талаарх судалгааг гаргаж Тамгын газарт 2018.07.25-ны өдөр тус тус хүргүүлсэн байна.

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагад бичиг баримтын хуурмаглал илрүүлэх төхөөрөмжөөр гадаадын иргэдийн баримт бичиг шалгасан 2018 оны хоёрдугаар улирлын тайланг гаргаж тус байгууллагад хүргүүлсэн.

Үүнээс гадна хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх зааварчилгаатай албан хаагчдыг өдөр бүр танилцуулж, гарын үсэг зуруулан ажиллаж байна.

## 2.2. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын талаар:

Бичиг хэрэгт 15 албан бичиг ирсэнийг бүртгэлжүүлэн холбогдох албан хаагчид хүлээлгэн өгч, хариутай 2 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан ба 9 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв.

Энэ сард тус газрын 4 албан хаагчаас ирүүлсэн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэн, хариуг хүргүүлсэн бол иргэн, ААН, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол байхгүй болно.

Тус газрын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Буянт-Ухаа дахь газрын даргын батлан гаргасан тушаал, тус газарт ирсэн, явсан албан бичиг, тус газрын энэ сарын төлөвлөгөө, түүний биелэлт, тайланг сканердаж цахим хэлбэрт шилжүүлсэн.

## 2.3. Хүний нөөц, сургалтын талаар:

ГИХГ-ын даргын 2017 оны Б/51-р тушаалаар тус газрын батлагдсан орон тоо 29 бөгөөд одоо ажиллаж буй 28, хүүхэд асрах чөлөөтэй 2, баталсан хуваарийн дагуу ээлжийн амралтаа эдэлж байгаа 5 албан хаагч байгаа бөгөөд энэ сард сахилгын арга хэмжээ авагдсан албан хаагч байхгүй болно.

Байгууллагын даргын 2018.07.06-ны өдөр баталсан Б/202 дугаар тушаалын дагуу тус газрын 1 албан хаагч 13 хоногийн цалингүй чөлөө, тус газрын даргын 2018.06.26-ны өдөр баталсан А/16 дугаар тушаалын дагуу 1 албан хаагчид нэг сарын албан тушаалын цалинг нэг удаа, мөн өдрийн А/17, А/18 дугаар тушаалын дагуу 2 албан хаагчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх мөнгөн тусламж тус тус олгосон байна.


Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан олон жил ажил хөдөлмөрөөрөө бусдыгаа хошуучлан амжилт гарган ажилласан тус газрын 1 албан хаагч Хууль зүйн албаны тэргүүний ажилтан, 5 албан хаагч ХЗДХЯ-ны “Хүндэт жуух бичиг”-ээр тус тус шагнагдсан ба төрийн захиргааны 9, төрийн үйлчилгээний 2 албан хаагчдад мөнгөн урамшил олгов.

Байгууллагын даргын 2018 оны Б/188, Б/190 дугаар тушаалаар тус газарт шилжин томилогдон ирсэн 2 албан хаагчийн талаарх мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн цахим програмд оруулсан.

Тайлант хугацаанд төв болон тус газраас зохион байгуулсан дараах сургалтуудад албан хаагчид хамрагдав. Үүнд:

- Төвөөс 2018.06.26-ны өдөр Засгийн газрын 2018 оны 145, 146, 147 дугаар тогтоолоор баталсан журмуудаар зохион байгуулсан сургалтад тус газрын албан хаагчид хамрагдлаа.

- Тус газар 2018.06.25-ны өдөр “Терроризмтой тэмцэх ажлыг зохион байгуулах”, “Байгууллагын аюулгүй байдлыг хангахад анхаарах зүйл” сэдвээр 23 албан хаагчдад сургалт зохион байгуулав.



Сургалтаар тус газрын албан хаагчид Монгол Улсын терроризмтой тэмцэх тогтолцоо, олон улс болон Монгол Улсын терроризмын өнөөгийн нөхцөл байдал, байгууллагын үйл ажиллагаанд ашигладаг “ISM” програм, байгууллагын нууцад хамаарах зүйлсийн хадгалалт, хамгаалатыг хангаж ажиллах талаар хэлэлцэв.



- Тус газар нь Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтэстэй хамтран нэг бүрийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх арга зүйн сургалтыг 2018.07.23-ны өдөр гадаадын иргэний хяналтын улсын байцаагч нарт зохион байгуулав. Арга зүйн сургалтаар нийт 10 гадаадын иргэний хяналтын улсын байцаагч нар нэг бүрийн тусгай хэрэгсэл болох гав, цахилгаан гүйдлээр цохигч, резинэн бороохой, тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл болох хурд сааруулагч, торон хаалт, дугуй хагалагч хадаас, хамгаалах тусгай хэрэгсэл болох нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, резинэн болон хуванцар сумтай буу хэрэглэх арга, бие хамгаалах урлагийн зэвсэггүйгээр тулалдах мэх болох боох мэх, тонгор мэх, өчих мэх, хутга мэс хариулах мэх, бие хамгаалах хариу цохилт хийх талаар сурч мэдлэгээ бататгав.



Түүнчлэн төвөөс 2018.06.29-ний өдөр байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Засгийн газрын 2018 оны 145, 146, 147 дугаар тогтоолоор баталсан журмуудаар авсан шалгалтад тус газрын ээлжийн ажил гүйцэтгэж буй, ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй албан хаагчдаас бусад 15 албан хаагч хамрагдав.

#### 2.4. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар:

Тайлант хугацаанд батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан ба холбогдох мэдээллийг шилэн дансанд байршуулсан.

Батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан. Батлагдсан төсөв болох өссөн дүнгээр 330,417,200 төгрөгийн санхүүжилт орсноор цалин хөлсөнд 183,287,297 төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл 20,947,690 төгрөг, ХУД-т цалин хөлснөөс суутгасан ашгийн татварт 13,857,440 төгрөг, хангамж, бараа материалын зардалд 15,422,000 төгрөг зарцуулж өглөг авлага үүсгээгүй ажиллалаа.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг 2018.07.02-ны дотор гарган ХУД-ийн төрийн сангаар баталгаажуулан ГИХГ-ын Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн. Мэдээгээр

281,223,900 төгрөгийн урсгал санхүүжилт орсоноос нийт зарлага 227,494,462 төгрөгийн ажил үйлчилгээ явуулж өглөг авлагагүй ажилласан.

НДШ-ийн тайланг гарган 2018.07.05-ны дотор НДХ-т хүргүүлэн 20,947,690 төгрөгөөр тооцоо нийлэв.

Тус газрын 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг нэгтгэн гаргаж ГИХГ-ын Санхүүгийн хэлтэст 2018.07.10-ны өдөр хүргүүлсэн.

Албан хаагчдад үнэт цаас болох визийн хуудас 600 ширхэгийг шаардах хуудасны дагуу олгосон. Түүнчлэн авто машины ашиглалт болон шатах тослох материалын тооцоог жолооч дэвтэрт бичилтийг хийн бүртгэл хөтлөв.

Хангамж, бараа материалын зардалд 15,422,083 төгрөгийн худалдан авалт хийж, албан хаагчдыг шаардлагатай бараа материалаар хангаж ажилласан.

Албан хэрэгцээнд ашиглаж байгаа суурин утас болон интернетийн төлбөрт 2,042,700 төгрөг, байрны түрээс 10,660,000 төгрөг харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дагуу холбогдох данс руу шилжүүлсэн болно.

Хүү торгууль 13,830,000 төгрөгийг Төв аймгийн төрийн санд, визийн тэмдэгтийн хураамж 191,783,440 төгрөг, визийн хуудас 25,337,390 төгрөгөөр тайлан нэгтгэн Хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлэн ГИХГ-ын Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.

Бараа материалын болон шатахууны тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн гаргасан ба хянуулж баталгаажуулсан.

Түлш шатах тослох материалд өссөн дүнгээр 9,997,200 төгрөгний зарцуулалт гаргаж тайлагнасан байна.

Тус газрын 28 албан хаагч, хүүхэд асрах чөлөөтэй 2 албан хаагчийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулав.

Үйлчилгээнд явж буй автомашины цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж, батлагдсан маршрутын дагуу албан хаагчдыг тээвэрлэж, замын хуудсыг бөглөн санхүүтэй тооцоо нийлж ажиллав.

#### 2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Сүлжээний болон техник хэрэгслийн нийт 14 дуудлага хүлээн авч засварласан. "ISM" системийн сүлжээ 2 удаа тасарсан ба тухай бүр холбогдох байгууллагын сүлжээ хариуцсан инженертэй холбогдон мэдээлэл авч, сүлжээг хурдан шуурхай хэвийн байдалд шилжүүлэн ажилласан. Түүнчлэн "Чингис хаан" олон улсын нисэх буудал дахь тус газрын харьяа өрөөний хананаас салсан байсан тог дамжуулах залгуурыг цахилгааны албанд дуудлага өгөн засварлуулж аюулгүй байдлыг хангасан.

Үндэсний их баяр наадмын өдрүүдэд тус газрын даргын баталсан хуваарийн дагуу ажилласан бөгөөд Буянт-Ухаа боомтод 2018.07.11-ний өдрөөс 15-ны өдрийн хооронд сүлжээний доголдол болон техник хэрэгслийн гэмтэл гараагүй, хэвийн ажилласан ба энэ талаар тухай бүр ГИХГ-ын сүлжээний инженертэй холбогдож мэдэгдсэн болно.

Үүнээс гадна Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 145, 146, 147 дугаар тогтоолоор баталсан журмууд болон нэмэлт, өөрчлөлтийн талаар англи, монгол хэл

дээр бэлтгэсэн гарын авлагыг 40 ширхэгийг хэвлэж, Буянт-Ухаа боомтоор зорчиж буй гадаадын иргэдэд түгээж танилцуулсан.

#### Гурав. Бусад

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2018 оны А/227 дугаар “Хариуцлагатай эргүүл, жижүүрийн ажиллах хуваарь батлах тухай” тушаалын дагуу тус газар Үндэсний их баяр наадмын өдрүүдэд ажиллах ГИХГ-ын Буянт-Ухаа дахь газрын хариуцлагатай эргүүл, жижүүрийн хуваарийг гаргаж 2018.07.02-ны өдөр, баяр наадмын өдрүүдэд ажилласан тухай илтгэх хуудсыг 2018.07.18-ны өдөр Боомт, орон нутгийн хэлтэст тус тус хүргүүлсэн болно.

Батлагдсан хуваарийн дагуу тус газрын хариуцлагатай эргүүл, жижүүрүүд баярын өдрүүдийн нөхцөл байдлын мэдээг 10:00, 18:00 цагуудад Гадаадын иргэн, харьяатын газрын хариуцлагатай эргүүл, жижүүрт тухай бүр өгч ажиллалаа.

Байгууллагын даргын 2018.07.10-ны өдөр баталсан 1-10/09 дугаартай “Буянт-Ухаа дахь газарт дотоод аудитын шалгалт зохион байгуулан ажиллах тухай” удирдамжийн дагуу ирсэн шалгалтын комисст шаардсан материалыг тухай бүр гарган өгч ажиллалаа.

ГИХГ-ын Буянт-Ухаа дахь газар нь дотоод үйл ажиллагаандаа ашиглах зорилгоор тус газрын үйл ажиллагааны талаарх статистик мэдээ агуулсан эмхэтгэлийн төслийг боловсруулж Буянт-Ухаа боомтод олгосон виз, түр ирэгчийн бүртгэл, хасалт, оршин суух зөвшөөрлийн хасалт, захиргааны зөрчил, албадан гаргасан гадаадын иргэн, хил дээрээс буцаасан иргэний талаарх 2016, 2017, 2018 /2018 оны тоон мэдээг эхний хагас жилийн байдлаар тусгасан/ оны тоон мэдээг он, улс, зөрчлийн төрөл зэргээр ангилсан бөгөөд хүний нөөцтэй холбоотой тоон мэдээлэл болох орон тоо, мэргэжил, боловсрол, нас, хүйс, гадаад сургалт, шагнал, сахилга, цалин хөлсний талаарх мэдээллийг нэмж тусган баяжилт хийлээ.